



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ихтамир сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/07-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Архангай аймаг

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)

Аудитор Н.Энхчимэг

Утас: 7033-3019

Цахим хаяг: [Enkhchimegn@audit.gov.mn](mailto:Enkhchimegn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АДЛЗ. 03. ТЗ № 135  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ЦЭВЭЭНДОРЖ  
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Ихтамир сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн, мөрдөгдсөнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогууд сумын төсвийн орлогод нэмэгдэж төвлөрсөн.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 67.2 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,121,570.7	1,013,142.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	475,474.5	544,506.4
33	АВЛАГА	448,538.0	456,154.7
35	БАРАА МАТЕРИАЛ	197,558.1	12,481.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,351,842.7	3,912,752.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,351,842.7	3,912,752.0
39200	Биет хөрөнгө	8,217,386.9	3,867,794.6
39300	Биет бус хөрөнгө	134,455.8	44,957.3
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,473,413.4	4,925,894.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,473,413.4	4,925,894.0
51	Засгийн газрын хувь оролцоо	9,473,413.4	4,925,894.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,854,626.7	627,640.1
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.0	627,640.1
51200	Хуримтлагдсан үр дүн	4,208,336.1	3,631,483.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,410,450.6	666,770.1
52	Хяналтын бус хувь оролцоо	0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,473,413.4	4,925,894.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛАЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,441,723.0	1,903,996.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	318,271.3	818,394.7
110	Орлогын албан татвар	86,785.5	257,176.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	86,785.5	256,886.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	290.7
113	Хөрөнгийн албан татвар	144,530.3	148,656.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	86,955.5	412,561.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,915,075.7	468,619.9
120	Нийтлэг татварын бус орлого	2,915,075.7	468,619.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,208,376.0	616,981.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,548,081.6	1,165,619.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,548,081.6	1,165,619.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,966,911.0	1,114,157.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,056,191.8	429,872.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,570.3	53,359.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	152,045.0	213,835.1
2104	Хангамж, бараа материалын зардал	108,164.1	49,629.0
2105	Нормативт зардал	660,961.6	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,827.8	38,818.0
2107	Томилголт, зочны зардал	8,172.5	6,370.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	241,376.0	54,704.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	399,602.0	267,568.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,581,170.7	51,461.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,893,641.4	738,376.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	109,429.4	5,240,203.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИИТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,784,212.0	-4,501,826.8

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,242,535.0	1,574,806.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	318,271.3	818,394.7
110	Орлогын албан татвар	86,785.5	257,176.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	86,785.5	256,886.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	290.7
113	Хөрөнгийн албан татвар	144,530.3	148,656.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	86,955.5	412,561.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,739.4	19,743.8
1181	Газрын төлбөр	336.3	37,828.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	66,879.7	354,989.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,396.4	139,430.2
120	Нийтлэг татварын бус орлого	176,396.4	139,430.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,747,867.3	616,981.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,461,148.6	965,286.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,461,148.6	965,286.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,296,696.7	912,471.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,056,191.8	429,792.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,570.3	53,440.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,980.4	213,835.1
2104	Хангамж, бараа материалын зардал	98,479.9	49,628.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,232.9	38,818.0
2107	Томилголт, зочны зардал	8,172.5	6,370.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,681.0	54,704.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,066.6	65,882.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164,451.8	52,814.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-218,613.6	609,520.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	158,585.4	450,488.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	158,585.4	450,488.4
2200	Дотоод эх үүсвэрээр	158,585.4	450,488.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-158,585.4	-450,488.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-90,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	90,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-377,199.0	69,031.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	852,673.5	475,474.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	475,474.5	544,506.4

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,689,201.4	7,689,201.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	339.3	339.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,689,540.6	7,689,540.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-339.3	-339.3
5	Тайлант үеийн үр дүн	1,784,212.0	1,784,212.0
6	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,473,413.4	9,473,413.4
7	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,473,413.4	9,473,413.4
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-45,692.5	-45,692.5
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,427,720.9	9,427,720.9
10	Тайлант үеийн үр дүн	-4,501,826.8	-4,501,826.8
11	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,925,894.0	4,925,894.0

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,699,726.50	1,438,905.60	260,820.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,048,693.50	950,467.90	98,225.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	993,128.30	900,006.00	93,122.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,793.50	429,792.20	21,001.30
210101	Үндсэн цалин	450,793.50	362,545.80	88,247.70
210102	Нэмэгдэл		45,424.10	-45,424.10
210104	Урамшуулал		21,461.30	-21,461.30
210105	Гэрээт ажлын хөлс		360.90	-360.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,349.40	53,440.00	2,909.40

**Архангай аймгийн Ихтамир сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	38,317.30	36,436.30	1,881.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,508.30	4,293.60	214.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,606.30	3,427.30	179.00
210204	Ажилгүйдлийн даатгал	901.70	838.30	63.40
210205	Эрүүл мэндийн даатгал	9,015.80	8,444.50	571.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,176.60	213,835.10	1,341.50
210301	Гэрэл, цахилгаан	35,976.50	48,053.20	-12,076.70
210302	Түлш, халаалт	158,140.60	149,915.60	8,225.00
210303	Цэвэр, бохир ус	21,059.50	15,866.20	5,193.30
2104	Хангамж, бараа материалын зардал	51,947.00	49,628.90	2,318.10
210401	Бичиг хэрэг	5,220.00	5,093.80	126.20
210402	Тээвэр, шатахуун	19,100.00	18,650.10	449.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,840.00	6,515.00	325.00
210404	Ном, хэвлэл	3,759.80	2,346.50	1,413.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,096.00	16,092.30	3.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	931.20	931.20	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,802.90	38,818.00	24,984.90
210604	Урсгал засвар	63,802.90	38,818.00	24,984.90
2107	Томилолт, зочны зардал	6,800.00	6,370.00	430.00
210702	Дотоод албан томилолт	6,800.00	5,370.00	1,430.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,928.80	40,889.00	17,039.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,006.40	39,737.80	16,268.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,336.00	1,076.00	260.00
210803	Даатгалын үйлчилгээ	120.70	0.01	120.69
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240.00	25.00	215.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	105.50	0.01	105.49
210807	Газрын төлбөр	120.20	50.20	70.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,330.10	67,232.80	23,097.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,330.10	63,371.40	22,958.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000.00	3,861.40	138.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,565.20	40,461.90	15,103.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,565.20	10,461.90	45,103.30
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,635.20	17,734.10	3,901.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,930.00	32,727.80	1,202.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	532,253.00	398,437.70	133,815.30
222001	Тоног төхөөрөмж	4,000.00	3,862.00	138.00
223001	Бусад хөрөнгө	528,253.00	394,575.70	133,677.30
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	118,780.00	90,000.00	28,780.00
230001	Эргэж төлөгдөх зээл	118,780.00	90,000.00	28,780.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,699,726.50	1,282,631.60	417,094.90
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		0.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих		0.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,144,423.00	1,178,925.50	-34,502.50
320001	Орон нутгийн төсвөөс	997,454.50	1,031,957.00	-34,502.50
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	146,968.50	146,968.50	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	555,303.50	103,706.30	451,597.20
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	161,420.00	103,706.30	57,713.70
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	393,883.50	0.01	393,883.49
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	282,375.50	-282,375.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	124,749.10	-124,749.10
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	141.00	139.01	1.99
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00	0.00
610001	Төсвийн байгууллага	3.00	3.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	69.00	68.01	1.00
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	44.00	43.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	69.00	68.00	1.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12.00	12.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	48.00	47.00	1.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00	0.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ДҮН
II	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,516.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,516.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,516.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,516.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,516.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,000.00

**Архангай аймгийн Ихтамир сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

223001	Бусад хөрөнгө	40,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,516.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,516.20
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	381.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,134.60

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар залруулагдаагүй нийт **402,090.5** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүллээ

#### 3.1 Албан шаардлага

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тулган шалгахад 99 зээлдэгчтэй холбоотой чанаргүй 305,043.0 төгрөгийн төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, мөн 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу төвлөрүүлэхэд онцгой анхаарч, зээлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

- Төсвийн орлогын гүйцэтгэл тайлант жилд 8-н нэр төрлийн 65,767.1 мянган төгрөгөөр тасарсан нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, орлогын төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн хийж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэх албан шаардлагыг хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг тулган шалгахад сангийн хөрөнгөөр хийгдсэн Тайхир чулууны тохижилт, ариун цэврийн байгууламжийн 25,555.9 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаж орлогод аваагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг орлогод авч зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ихтамир сумын ТТЗ	2	54388.3			2	54388.3							

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ихтамир сумын ТТЗ	1	0	0	0	1	0	0	0